



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/51

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6.1, 6.2, 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Ж.Чимэддулам (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)
О.Отгонтуяа (Санхүүгийн албаны дарга)
Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
И.Маралмаа (Газрын даамал)
Э.Буянтогтох (Хөдөө аж ахуй тасгийн мэргэжилтэн)
А.Аюушжав (Мал эмнэлгийн улсын байцаагч)
Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)
А.Мандахзул (Иргэний төлөөлөл)
Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Г.Цэрэндулам (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2. Багуудаас гарсан саналыг журмын дагуу боловсруулж, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь нэгтгэн боловсруулж, зөвлөмж, дүгнэлтийг гарган ирүүлэхийг ажлын хэсэг (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

